



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 183/Ш32019/07593

Улаанбаатар хот

Талуудын эвлэрлийг баталгаажуулах тухай

Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.Эрдэнэчимэг би,

Өргөдөл гаргагч: Сүхбаатар дүүрэг, 5 хороо, Үндсэн хуулийн гудамж, “Ньюмайд Групп” ХХК-ийн байр, “Лэндмн ББСБ” ХК-ийн, /РД:5039754/ нэхэмжлэлтэй,

Уригдагч: Увс аймаг, Давст сум, 3 баг, Хандгайтад бүртгэлтэй, Хан-Уул дүүрэг, 10 хороо, 3 гудамж, 30 тоотод оршин суух, Зуутраг овогтой Цэдэндоржийн Буянхишигт /РД: ОВ92081911/ холбогдох,

Зээлийн гэрээний үүрэг 563,400 /таван зуун жаран гурван мянга дөрвөн зуун/ төгрөг гаргуулах тухай маргаанд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан эвлэрлийн гэрээг хүлээн авч, хянаад

ТОДОРХОЙЛОХ нь:

Өргөдөл гаргагч нь шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид гаргасан өргөдөлдөө: Ц.Буянхишиг нь лэндмн аппликейшнаар дамжуулан гаргасан хүсэлтийн дагуу 2018 оны 4 сарын 19-ний өдөр 550.000 төгрөгийг, 33,700 төгрөгийн шимтгэлтэй, 30 хоногийн хугацаатай 2018 оны 5 сарын 19-ний өдөр бүрэн эргэн төлөх нөхцөлтэйгөөр түүний Худалдаа хөгжлийн банкны 450007398 дансанд шилжүүлсэн боловч Ц.Буянхишиг зээлийн гэрээний 4.2.2 дах заалтыг зөрчиж үндсэн зээлээ өнөөдрийг хүртэл төлөөгүй учир нийт 563,400 төгрөгийг гаргуулахаар эвлэрүүлэн зуучлалд хандаж байна гэв.

Уригдагчаас гаргасан тайлбартаа: “Лэндмн ББСБ” ХК-ийн нэхэмжилсэн 563,400 төгрөгийг хүлээн зөвшөөрч, 2019 оны 6 сарын 30-ны өдөр 250,000 төгрөг, 2019 оны 7 сарын 30-ны өдөр 313,400 төгрөгийг төлж барагдуулна гэжээ.

Талуудын байгуулсан эвлэрлийн гэрээнд: Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад Ц.Буянхишиг нь өргөдлийн анхны шаардлага 563,400 төгрөгийг хүлээн зөвшөөрч, 2019 оны 6 сарын 30-ны өдөр 250,000 төгрөг, 2019 оны 7 сарын 30-ны өдөр 313,400 төгрөгийг, улсын тэмдэгтийн хураамжийн 9,080 төгрөгийн хамт төлж барагдуулахаар эвлэрэв гэжээ.

Шүүх өргөдөл, тайлбар эвлэрлийн гэрээ, баримттай танилцаад ҮНДЭСЛЭХ нь:

Талууд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгчтэйгээр гэрээ байгуулж, Ц.Буянхишиг нь өргөдлийн шаардлага 563,400 төгрөгийг хүлээн зөвшөөрч, 2019 оны 6 сарын 30-ны өдөр 250,000 төгрөг, 2019 оны 7 сарын 30-ны өдөр 313,400 төгрөгийг, улсын тэмдэгтийн хураамжийн 9,080 төгрөгийн хамт төлж барагдуулна гэснээр эвлэрчээ.

Өргөдөл гаргагч “Лэндмн ББСБ” ХК нь 2019 оны 5 сарын 24-ний өдрийн 6/71 дугаартай итгэмжлэлээр А.Билгүүнд эвлэрэх эрхийг олгосон ба энэхүү эвлэрлийн

гэрээ нь Иргэний хуульд нийцсэн, гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хөндөөгүй байх тул Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т зааснаар талуудын эвлэрлийг баталгаажуулах нь зүйтэй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74¹ дүгээр зүйлийн 74¹.5-д заасныг удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасныг баримтлан Ц.Буянхишиг нь өргөдлийн шаардлага 563,400 төгрөгийг хүлээн зөвшөөрч, 2019 оны 6 сарын 30-ны өдөр 250,000 төгрөг, 2019 оны 7 сарын 30-ны өдөр 313,400 төгрөгийг, улсын тэмдэгтийн хураамжийн 9,080 төгрөгийн хамт “Лэндмн ББСБ” ХК-д төлж барагдуулна гэснээр эвлэрснийг баталгаажуулсугай.

2. Өргөдөл гаргагч улсын тэмдэгтийн хураамжид 18,161 төгрөг төлснийг дурдсугай.

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74¹ дүгээр зүйлийн 74¹.9-д зааснаар маргааныг эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэсэн тохиолдолд талууд давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах, тухайн асуудлаар анхан шатны шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүйг тайлбарласугай.

ШҮҮГЧ



Ж.ЭРДЭНЭЧИМЭГ